

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн



Төрийн сангийн тогтолцоо бүрдсэн ч сумдын тогтолцоо оновчтой бус байна.

Даланзадгад хот
2018 он

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

Агуулга

<p>Аудитыг гүйцэтгэсэн:</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт.....3</p>
<p>Дарга, Тэргүүлэх аудитор</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4-5</p>
<p>П.Алтанзаяа</p>	<p>Бүлэг 1. Төрийн сангийн тогтолцоо бүрдсэн ч зарим талаараа оновчгүй зохион байгуулагдаж байна.....6</p>
<p>Аудитын менежер</p>	<p>Бүлэг 2. Сумдын төрийн санд дотоод хяналт хийгддэг ч алдаа зөрчлүүд давтан гарсаар байна.....9</p>
<p>Ж.Болормаа</p>	<p>Дүгнэлт.....14</p>
<p>Аудитор</p>	<p>Зөвлөмж.....15</p>
<p>Г.Шижирболд</p>	<p>Хавсралт №</p>
<p>Б.Номинцэцэг</p>	<p>Тайлан баталгаажуулсан тушаал.....16</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу</p>	
<p>ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 305 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг</p>	



Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨААТ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
НББ	Нягтлан бодох бүртгэл

АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг үндэслэн Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Аймгийн төрийн сангийн хэлтсийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэж, аймгийн төрийн сангийн хэлтэс болон сумдын төрийн санчид хамрагдав.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гарсан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж горим сорилын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙХЭД АШИГЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай -2013
- Санхүүгийн алба байгуулах тухай -2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам -2015

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам -2012
- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам -2013
- Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банкинд нээх, хаах журам -2013
- Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам - 2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам -2014
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам 2014
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн төлөвлөлтийн журам -2014
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар -2015
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам -2016
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам болон бусад холбогдох хууль, журмуудыг ашиглана -2017

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа удирдаж, аудитын менежер Ж.Болормаа үе шатны хяналт хийж, аудитор Г.Шижирболд, Б.Номинцэцэг нар 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Төрийн сангийн тогтолцоо бүрдсэн ч зарим талаараа оновчгүй зохион байгуулагдаж байна

Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулах талаар Засгийн газрын тогтоолоор төрийн сангийн үйл ажиллагааны журам, Монгол банктай хамтарч Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банкинд нээх, хаах журам, Сангийн сайдын тушаалаар Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам, Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам зэрэг эрх зүйн актууд батлагдан гарсан байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлд Төрийн сангийн нэгдсэн данс, 36 дугаар зүйлд Төрийн сангийн тогтолцоо, 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг тодорхойлсон байна. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т *“Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна”* гэж заасан байна. Аймгийн ЗДТГ-ын даргын 2016 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн А/115 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-ын орон тоо, ажлын байрны чиг үүргийг батлахдаа СТСХ-ийг аймгийн ЗДТГ-ын дотор байхаар заасан нь дээрхи заалттай нийцэхгүй байна.

Төрийн сангийн үндсэн чиг үүргийг аймгийн Төрийн сангийн хэлтэс нь 7 орон тоотойгоор, суманд Төрийн сангийн төлөөлөгч гэсэн 1 албан тушаалтан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн төрийн сангийн төлөөлөгч нь албан тушаалын ТЗ-5 ангилал, сумдын төрийн сангийн төлөөлөгч ТЗ-3, зарим сумдын төлөөлөгч ТҮ-6,7,8 ангиллалаар цалинжиж байна. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор сумдад санхүүгийн алба байгуулагдан ажилласан байна. Суманд төрийн сангийн чиг үүргийг гүйцэтгэж буй төрийн сангийн төлөөлөгч, бүртгэлийн дансны гүйлгээ хянаж баталгаажуулж байгаа Санхүү албаны дарга бөгөөд ерөнхий санхүүчийг эзгүй амралттай, өвчтэй байх хугацаанд ажил үүргийг шилжүүлэн гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг ба түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Сумдын нягтлан бодогч нар нь гүйлгээг сарын сүүлчээр бөөн хийдэг нь төрийн санчдын сар, улирлын сүүлчээр ажлын ачаалал ихэсдэг байна. Мөн сумдад харилцан адилгүй ажлын ачаалал үүсч байна. Тухайлбал: Даланзадгад сумын төрийн санч 38 дансны гүйлгээг хянаж баталгаажуулдаг бол Баяндалай сумын төрийн санч 16 дансны гүйлгээг хянаж баталгаажуулдаг байна. Зарим

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

суманд төрийн сангийн төлөөлөгч өдөрт нэг гүйлгээ хийж байгаа ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна.

Сумын төрийн сангийн төлөөлөгч нь төрийн сангийн үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Статистикийн тухай хуулийн 11.2-д “Суманд статистикийн үйл ажиллагааг ЗДТГ-ын уг ажлыг хариуцсан ажилтан эрхлэн гүйцэтгэнэ” гэж заасан байна. Мөн МУ-ын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолын 1.2.4-т төрийн сангийн төлөөлөгч “статистик мэдээллийг гаргах” гэж зааснаар сумдын төрийн сангийн төлөөлөгч статистикийн ажлыг давхар гүйцэтгэж байна. Давхар ажил хавсарсан урамшуулал, нэмэгдэл цалин олгодоггүй байна. Сумын төрийн сангийн бүтэц зохион байгуулалтыг харгалзан үзэж, сум орон нутагт Төрийн сангийн хүний нөөцийн асуудлыг оновчтой шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2016 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн А/115 дугаар тушаалаар СТСХ-ийн орон тоо, чиг үүргүүдийг баталсан байна. СТСХ-ийн чиг үүргүүд бусад газар хэлтсүүдийн ажлыг чиг үүрэгтэй давхцаагүй байна.

СТСХ нь 2017 оны үйл ажиллагааны тайлангаа 2018 оны 03 дугаар сарын 17-ны өдөр аймгийн ЗДТГ-т хүргүүлжээ. Үйл ажиллагааны тайланд дараах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлаа тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлага, авлага, өглөгийн мэдээг хуулийн хугацаанд багтаан үнэн зөв гаргасан байх
- Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд багтаан үнэн зөв гаргасан байх
- Тусгай зориулалтын шилжүүлгийг байгууллагууд болон орон нутгийн төсөвт байгууллагуудын өр авлагыг барагдуулах ажлыг тогтмолжуулах, нэмж үүсэх урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авч өмнөх оны гүйцэтгэлээс бууруулсан байх
- Шууд удирдлагадаа ажилладаг төрийн сангийн болон төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэл тооцооны ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж заавар зөвлөгөө өгч сургалт семинар зохион байгуулсан байх
- Сумдын санхүүгийн албаны жилийн ажлын дүнг энэхүү журамд дурдагдсан үзүүлэлтүүдийн дагуу үнэлж дүгнэсэн байх
- СУМС-ийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байх, системд алдаатай бүртгэгдсэн, түр хадгалагдсан гүйлгээгүй байх, жилийн эцсийн хаалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байдал
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл, түүний төлөвлөгөөний биелэлт
- Гадаад дотоод зээл, уг эх үүсвэрээс дамжуулах зээлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх
- Дотоод хяналтын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөт болон өдөр тутмын хэсэгчилсэн хяналтыг хэрэгжүүлсэн байх

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

- Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журамд заасан хугацаанд багтаан үнэн зөв мэдээлсэн байх
- Тухайн жилийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт
- ИТХ-аар батлагдсан орон нутгийн төсвийн тогтоолыг сангийн яаманд хүргүүлэх, батлагдсан төсөв болон Засаг даргын баталсан төсвийн хуваарийг тухай бүрд нь мэдээллийн системд үнэн зөв оруулсан байдал.
- Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, журмыг баримталсан эсэх
- Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсээс сум, дүүргээр баталсан ОНХС-ийн хэмжээ болон ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг тухай бүр сум, дүүрэгт хуваарилж системд оруулсан эсэх
- Аймаг, нийслэл, сум, дүүрэг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг ОНХС-ийн системд хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн оруулсан эсэх
- Орон нутагт харьяалалтай аж ахуй нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн хүлээн авалт, баталгаажуулалтын хувь, орон нутгийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагаанд оролцож буй аж ахуй нэгжийн санхүүгийн тайланг И-баланс программаас гаргаж ашигласан байх зэрэг зорилтууд багтсан байна.

Аймгийн СТСХ нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг мөрдлөг болгон төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төсвийн үйл явцыг бодлогын удирдамжаар хангах, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, төсвийн орлогын бололцоотой бүх эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой хуваарилах, үр өгөөжтэй ашиглах, аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ЗГУМС-д зөв зохистой ажиллах, төсөвт байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих зэрэг үйл ажиллааг зохион байгуулах ажлыг үр дүнгийн гэрээнд тусгаж СТСХ-ийн дарга Б.Наранхүүгийн 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтэнд аймгийн ЗДТГ-ын дарга 90,4 А үнэлгээ өгсөн байна.

Бүлэг 2

Сумдын төрийн санд дотоод хяналт хийгддэг ч алдаа зөрчлүүд давтан гарсаар байна.

Аудитын явцад Аймгийн СТСХ болон Даланзадгад, Баяндалай, Цогт-Овоо, Сэврэй, Булган, Мандал-Овоо, Ханхонгор сумдад албан томилолтоор ажиллаа. Сумдын төрийн санд гарч байгаа нийтлэг алдаа зөрчлүүдийг дурдвал:

- Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны 24-р тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5-7.7-д заасан бүрдэл хангаагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн.
- Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчиж төлбөр тооцоо хийсэн.
- Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-ыг зөрчиж цалингийн зардлаас бэлэн мөнгөний дансаар дамжуулсан.
- Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ батлагдсан төсөв, эдийн засгийн ангилал, үндэслэх баримт, хяналтын хуудсыг хянаж үндэслэх баримтанд энэ тухай тэмдэглэлийг хийсэн байдал хангалтгүй зэрэг зөрчлүүд байна.

Төрийн сангийн бүртгэлийн дансанд гүйлгээ хийж буй байгууллагын төлбөрийн хүсэлтийн данс зөрүүтэй, гүйлгээ шивэгч нягтлан бодогчдын шивэлт алдаатай, дотоод хяналтын мэргэжилтэн, сумдын санхүү албаны дарга, ерөнхий санхүүчид хяналт сул тавьж байгаагаас шалтгаалан нэр данс зөрүүтэй гүйлгээ ихээхэн гарч байна.

Төрийн сангийн бүртгэлийн дансаар дамжуулан аймгийн хэмжээнд 2017 онд 37,106 гүйлгээг хийсэн байна. Төрийн сан нь төсөвт байгууллагуудын ажил гүйлгээг хийхдээ 794 ажил гүйлгээг алдаатай хийсэн бөгөөд орлого бууруулах 105 гүйлгээ хийсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцэст төвлөрүүлэх 87,5 сая төгрөгөөр сургуулийн өмнөх боловсролын байгууллагад үүссэн өр, төлбөрийг барагдуулсан нь Төсвийн тухай хуулийн дагуу төсөвт зохицуулалт хийх шат дараалсан арга хэмжээ зохион байгуулаагүй зөрчил төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрч СТСХ-ийн дарга Б.Наранхүүд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдсөн болно.

Хөрөнгө оруулалтын хувьд:

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/3 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 121 төсөл арга хэмжээнд 35,795.9

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

сая төгрөг, байгаль хамгаалах чиглэлээр 23 төсөл арга хэмжээнд 7,467.6 сая төгрөг зарцуулахаар тодотгон баталсан байна.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт (сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн Дүн
1	Барилга байгууламж	31	28,989.1
2	Тоног төхөөрөмж	46	6,253.5
3	Их засвар	57	7,630.8
4	Бусад	10	390.0
	Нийт	144	43,263.4

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 383,7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна. (Хавсралт №2) Тухайлбал:

- Баяндалай сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажилд 17,5 сая төгрөг,
- Д3 сумын 11 дүгээр цэцэрлэгийн засварын ажилд 42,0 сая төгрөг,
- Д3 сумын 5 дугаар сургуулийн биеийн тамирын талбай байгуулж, хашаажуулах ажилд 16,8 сая төгрөг,
- Д3 суманд хөл бөмбөгийн талбай байгуулах ажилд 80,0 сая төгрөг,
- Ханбогд сумын хайрхан багийн орон сууц, ажлын байрны барилгын засварын ажилд 80,0 сая төгрөг,
- Д3 сумын орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд тоглоомын талбай байгуулах ажилд 32,0 сая төгрөг,
- Сэврэй сумын 80 ортой хүүхдийн дотуур байрны барилгын засварын ажилд 20,0 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.2² дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Цаашид төсвийг үр ашигтай зарцуулах, худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтийг захиран зарцуулахгүй байх албан шаардлагыг Аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласан.

Мөн нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.23 дахь заалтын дагуу бүртгэлгүй байгаа хөрөнгийг бүртгэлд тусгуулах тухай албан шаардлагыг орон нутгийн өмчийн газрын даргад албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Даланзадгад сумын хөл бөмбөгийн зориулалтын талбай 889.9 сая төгрөг,
- Жуулчны гудамж байгуулах 68,2 сая төгрөг,

¹ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй.

³ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

- Ханбогд сумын төвийн дулааны шугам сүлжээний өргөтгөл 378,4 сая төгрөг,
- Даланзадгад сумын 26 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн 24.5 сая төгрөгийн тоглоом,
- Даланзадгад суманд өвлийн хүлэмж байгуулах 360,0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 131 дүгээр ангийн хяналтын камер 5.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтууд байна.

ЗГСУМСистемийг аймгийн төрийн сангийн хэлтэс болон 15 сумдын төрийн санд ашиглагдаж байна. Тус системээр дамжуулан бүх төсөвт байгууллагын төлбөр тооцоог хийж гүйцэтгэхээс гадна төсөв, төлөвлөгөөг оруулж баталдаг нэгдсэн цогц систем бөгөөд системийг аймаг, сумдын төрийн санд ашиглах функц бага ЗГСУМС-ийг хэрэглэхэд энгийн ойлгомжтой байдаг байна.

Аймгийн хэмжээнд тус системд нэвтрэх 35 эрх байдаг байна. Эдгээр эрхийг ашиглаж байгаа албан тушаалтнууд төрийн сангийн журмын дагуу тус программыг ашигладаг байна. СТСХ-т Ерөнхий нягтлан бодогч 1, төсвийн мэргэжилтэн 1, дотоод хяналтын мэргэжилтэн 1, төрийн сангийн мэргэжилтэн 2 эрхтэй, сумдуудад Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн тус бүр 1 эрхтэй байна. Тус ЗГСУМС-ийн хэрэглэгчийн хөдөлгөөний тайланг улирал бүр Сангийн яаманд хүргүүлжээ байна.

2017 оны байдлаар Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 9 системийн хэрэглэгчийн эрхийг шилжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Аймгийн төсвийн мэргэжилтэн Б.Батхүүгээс Э.Бор-Охинд,
- Төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн А.Адъяагаас Т.Хишигбат-д,
- Баяндалай сумын төрийн сангийн мэргэжилтэн Б.Мөнхгэрэлээс Ц.Хандармаад,
- Ноён сумын Санхүүгийн албаны дарга О.Цацралтуяагаас Б.Мөнхзулд,
- Ханбогд сумын төрийн сангийн мэргэжилтэн Т.Наранчимэгээс Н.Шанзмаад,
- Ханхонгор сумын төрийн сангийн мэргэжилтэн О.Зэсбаатараас А.Билгүүнд,
- Цогт-Овоо сумын төрийн сангийн мэргэжилтэн Б.Цэвэлмаагаас З.Шинэдэлгэрэхсайханд,
- Цогтцэций сумын Санхүүгийн албаны дарга В.Хүүхэндүүгээс Д.Мандах-д, мөн тус сумын төрийн сангийн мэргэжилтэн Г.Ууганцэцэгээс Г.Амарзаяад,
- Даланзадгад сумын Санхүүгийн албаны дарга Б.Азжаргалаас Д.Отгонбат-д, сумын төрийн сангийн мэргэжилтэн М.Галмандахаас Д.Бямбабаярт тус тус ЗГСУМСистемийн эрхийг “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам” -ын дагуу шилжүүлж Сангийн яамнаас зөвшөөрөл авч нээлгэсэн байлаа.

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

Аймгийн төрийн сангийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн төлөөлөгч, санхүү албаны дарга, ерөнхий санхүүч нарын төрийн сангийн нэгдсэн мэдээллийн системд нэвтрэх болон гүйлгээ хийх эрхийг Сангийн яаманд байгууллагын даргын албан тоотоор хүсэлт гаргаж нэвтрэх эрх буюу кодыг авдаг байна. Төрийн сангийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн төлөөлөгч, ахлах нягтлан бодогч нарын Төрийн сангийн нэгдсэн тогтолцооны мэдээллийн системд нэвтрэх эрхийг Сангийн яамнаас олгосон гүйлгээ хийх эрх зохих түвшиндээ нууц кодоор хязгаарлагдаж байна. ЗГСУМСистемд нэвтрэх нууц кодыг 7-14 хоног тутамд программаас анхааруулга санамж гарч шинэчлэгдэх боломжтой ба нууц кодыг бусдад мэдэгдсэн болон өөрчлөх шаардлага гарсан үед өөрчлөх бүрэн боломжтой байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд бүх сум Висат /антены/ кабелиар тус системд холбогддог байсан үед холболт нь удаан тус системээр дамжуулан төлбөр тооцоо хийж гүйцэтгэхэд хүндрэлтэй байсныг 2013 оноос эхлэн сумдуудад шат дараатайгаар шилэн кабельд холбож эхэлсэн байна. Ингэснээр тус системийн хэрэглэгчийн хандлага болон үр дүн сайжирч төлбөр тооцоог илүү түргэн шуурхай хийж гүйцэтгэдэг болсон байна.

2017 оны байдлаар Өмнөговь аймгийн Гурвантэс, Мандал-Овоо, Ноён, Цогтцэций сумдууд төрийн сангийн шилэн кабельд холбогдоогүй бөгөөд тус системийг ашиглахад удаан, гацах шалтгаан болдог байна.

Өмнөговь аймаг Сангийн яамтай хамтран ЗГСУМС-ийн сургалтыг жил бүр зохион байгуулж программ хангамжийн хэрэглээ болон хэрэглэгчдийг системтэй ажиллах ур чадварыг олгосон байна. Мөн сумдын санхүүгийн албадын тоног төхөөрөмжийг аюулгүй байх үүднээс 2016 онд аймгийн СТСХ-ээс компьютер болон дагалдах хэрэгслийг шинээр олгож системийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д *“Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нээжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ”* гэж заасны дагуу аймгийн СТСХ дотоод хяналтын мэргэжилтэнг ажиллуулж байна.

СТСХ-ийн мэргэжилтэн нь төсвийн гүйцэтгэлийн мэдээг ЗГСУМС-ээс шууд бэлтгэн гаргадагтай холбоотойгоор төсвийн гүйцэтгэлийн мэдээний чанарыг сайжруулахад системийн хяналтыг хэрэгжүүлж гаргасан алдаа зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгч биелэлтийг хангуулж ажилласан байна. Сар бүрийн эцэст төсвийн багцын тайланг хянаж зөрүүтэй сумд болон байгууллагуудын зөрүүг засуулдаг байна. “Free balance” программд хэрэглэгчийн үнэн зөв байгаа эсэхийг хянаж зөрүүтэй байгаа хэрэглэгчдийн судалгааг гаргаж Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж засуулдаг байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/184 дугаар захирамжаар дотоод хяналт хийх календарчилсан төлөвлөгөө батлуулж

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

6,7,10,11 дүгээр саруудад 15 суманд дотоод хяналт хийж гарсан зөрчлийг арилгуулж зөвлөмж өгч ажилласан байлаа.

Жил бүр дотоод хяналт сумдад ажилладаг ч гардаг зөрчлүүд давтагдсаар байна. Тухайлбал:

- Дарга, нягтлан бодогч, няравыг солигдсон тухай бүрт хувийн хэргийн бүрдэлд баяжуулалт хийдэггүй,
- ЗГ-ын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 24-р тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг зөрчиж бүрдэл болоогүй шаардлага хангахгүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийдэг байна. Үүнд: Төлбөрийн хүсэлтийн дугаар байхгүй, дарга, нягтлан бодогчийн гарын үсэг тамга бүрэн байхгүй, хүчинтэй хугацаа дууссан ... гм,
- Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ батлагдсан төсөв, эдийн засгийн ангилал, үндэслэх баримт, хяналтын хуудсыг хянаж үндэслэх баримтанд энэ тухай тэмдэглэлийг хийж ажиллаж байгаа байдал хангалтгүй,
- “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчиж цалингийн зардлаас бэлэн мөнгөний дансаар дамжуулсан,
- Төсөвт байгууллагуудын төсвийн санхүүжилтийг олгохдоо сумдын Засаг даргын гарын үсэг, тамгаар баталгаажсан төсвийн хуваарийг үндэслэж, санхүүжилтийн эрхийн тооцоог хийж ЗЭБ№1 маягтаар баталгаажуулан олгоогүй,
- Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчиж төлбөр тооцоо хийсэн,
- ЗГ-ын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 24-р тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.2 /төрийн сангийн өдрийн мемориалын баримтыг архивын стандартын дагуу архивын нэгж үүсгэнэ”-т заасныг зөрчиж архивын нэгж үүсгээгүй зэрэг зөрчлүүд аудитын явцад мөн дахин давтан гарч байлаа.

Иймд дээрх зөрчлүүд дахин давтан гаргахгүй сумдын төрийн санчдыг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 36.2-т “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Сумдын төрийн сангийн мэргэжилтний ажлын ачаалал харилцан адилгүй байна.
- Шилэн кабельд холбогдоогүй сумдын Төрийн сангийн сүлжээ тасалдал ихтэй программ дээр ажиллахад хүндрэлтэй байдаг байна.
- Сумын төрийн сангийн төлөөлөгч, бүртгэлийн дансны гүйлгээ шивдэг нягтлан бодогч амралттай, өвчтэй байх хугацаанд ажил үүргийг шилжүүлэн гүйцэтгэхэд түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нарт зөвлөх нь:

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж сумдын төрийн сангийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах
2. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтыг сайжруулах, дотоод хяналтаар гарсан зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах.
3. Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарах.
4. Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг чанд мөрдөх, хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд тухай бүрд нь хариуцлага тооцож байх
5. Төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс төрийн сангийн нэгдсэн системийн тасалдал, доголдол гарч байгаа шалтгааныг тодруулж программ хангамжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/27

Баланзадгад

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, дахь заалт, мөн 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх" –ийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. "Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг санхүүгийн аудитын баг /Г.Шижирболд/-т үүрэг болгосугай.

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ж.БОЛОРМАА

D.Bichig hereg/Tushaal-B-A4

710093